



ХААЛГАНЫ ЦААНА БАГШ ТӨВТ ХИЧЭЭЛ БАЙСААР...

Д.Амартүвшин^а

^а МУБИС-Багшийн сургууль, МБУТ

Холбоо барих зохиогч: Amartuvshind@msue.edu.mn 

Хүлээн авсан: 2024.08.25

Хянагдсан: 2024.09.20

Зөвшөөрсөн: 2024.10.25

Хураангуй

Энэхүү судалгаагаар Дундговь болон Төв аймгийн дөрвөн сумын ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн 178 суралцагчийн математикийн хичээлийг болон сэтгэл ханамжийг зуруулах аргаар чанарын үнэлгээ хийлээ. Математикийн хичээлээ зурахдаа судалгаанд хамрагдсан суралцагчдын дийлэнх нь буюу 32 хувь нь багшийг самбарт тайлбарлаж байгаагаар дүрслэн зуржээ. Энэ нь өнөөг хүртэл анги танхим дахь хичээл багш төвтэй байгааг илтгэх нэг хэлбэр гэж үзэж болох юм. Мөн эгнүүлж зассан ширээн дээр сууж, дэвтэртээ самбарт бичсэн бодлогыг бодож байгаа дүрслэл олонтоо давтагдсан нь суралцагчдын математикийн хичээл дээрх үйл ажиллагаа идэвхгүй байгааг илтгэнэ. Хүүхдүүд аз жаргалтайгаар инээмсэглэж байгаа, бие биедээ тусалж буй, туршилт хийж буй, тоглож буй, мэдлэгээ амьдралд хэрэглэж буй, гар утас, таблет, компьютер хэрэглэж буй дүр зураг огт харагдахгүй байгаа нь хичээл дээр ийм дүр зураг нийтлэг биш байгааг илтгэнэ. Сэтгэл ханамжийг зурах даалгавар дээр судалгаанд хамрагдсан суралцагчдын хичээлд ирэхдээ баяртай байсан байдал хичээл дээр буурч байгаа нь харагдаж байна. Энэ нь хичээл дээрх үйл ажиллагаа сонирхолгүй байгааг илтгэж байна хэмээн үзэж болохоор байна.

Түлхүүр үг

Үйл ажиллагаа, идэвхгүй сургалт, сэтгэл ханамж, математикийн хичээл

Удиртгал

Манай улсад 1990 оны ардчилсан хувьсгалаас хойш боловсролын салбарт арга зүйн томоохон өөрчлөлт өрнөсөөр ирсэн. 2019 онд хэвлэгдсэн “Боловсролын суурь мэдээллийн тайлан”-д дурдсанаар 2002 оноос мөрдөж эхэлсэн цогц чадамжид суурилсан суралцахуйн гол үзэл санаа нь суралцагчид бүтээлч үйл ажиллагааны явцад мэдлэг зохиомжлон бүтээх, түүнийгээ хэрэглэх, асуудлыг шийдвэрлэх зэрэг шинж чанар бүхий стандарт, үндэсний хөтөлбөр хэрэгжиж эхэлсэн гэжээ (БСҮХ, 2019). Тэгвэл цогц чадамжид суурилсан суралцахуйн үйл ажиллагааны идэвхгүй хэлбэр нь мэдээлэл сонсох, алгоритмчилсан үйлдлийг учир утгагүй давтах үйл

ажиллагаа болно. Мөн ЮНЕСКО-гийн тайланд боловсролын салбарын зорилго, үйл ажиллагаа, арга зүйн шинэчлэл нь цогц чадамж эзэмшүүлэх гэсэн үндсэн үзэл баримтлалаар хэрэгжиж байгааг дурджээ. (ЮНЕСКО, 2019)

2021-2022 оны хичээлийн жилд зохион байгуулсан бага боловсролын чанарын үнэлгээний шалгалтаар суралцагчдын гүйцэтгэл 36.62 хувьтай гарсан (БШУЯ, 2023) нь дараагийн шатны сургалтын үр дүнд сөргөөр нөлөөлөх хэмжээний үзүүлэлт юм. 2023 оны 12-р сард манай улс анх удаа PISA шалгалтад хамрагдсаны дүн гарахад манай улсын дундаж математик 425, унших чадвар 378, байгалийн ухааны чадвар 412 оноотой шалгагджээ. (<https://www.meds.gov.mn>, 2023). Эдгээр үзүүлэлт бага боловсролын чанарын асуудлыг боловсролын харилцаанд оролцогч бүх талууд анхаарч үзэх шаардлагатай байгааг харуулж байна.

АНУ-ын Үндэсний сургалтын лабораторийн хичээл дээр үйл ажиллагаануудын үр өгөөжийг урт хугацааны судалгаагаар сонсох үйл нь хамгийн бага буюу 5 хувийн үр дүнтэй гэж тогтоосон байдаг. (Lalley, J. P. & Miller, R.H. , 2007).

1990 оноос эдүгээ хүртэл манай улсын боловсролын хөтөлбөр 21 удаа их, бага өөрчлөлт орсон байна. (ЮНЕСКО, 2019). Эдгээр өөрчлөлтийг бүхэлд нь харахад арга зүйн хувьд суралцагчид бүтээлч үйл ажиллагаанд оролцуулснаар өөрсдөөр нь мэдлэг зохиомжлуулан бүтээлгэх үзэл санаа өөрчлөгдөөгүй байна. Гэвч анги танхим дахь үйл ажиллагааг бүтээлч байдлаар зохион байгуулах, суралцагчдыг идэвхтэй үйл ажиллагаанд оролцуулах нь бага төдийгүй хаалганы цаана багш тайлбарлах, сонсох, дуурайн бодох, ашиггүй олон илэрхийлэл жишээ бодох зэрэг идэвхгүй үйл ажиллагаанаасаа салаагүй байна. Энэ асуудал зөвхөн манай улсад төдийгүй олон улсын томоохон судалгаагаар дэлхий даяар бүрэн шийдэгдээгүй байгааг харж болно. Тухайлбал, OECD байгууллагаас зохион байгуулдаг багшлахуй ба суралцахуйн олон улсын судалгаа болох TALIS-2018 тайлан дээр судалгаанд хамрагдсан багш нарын 50 хувь нь идэвхтэй сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж чадахгүй байна гэж хариулсан байна. (Schleicher, 2018).

Бид анги танхим дахь хичээлийн үйл ажиллагааг бүтээлч, үр өгөөжтэй, сонирхолтой болгохгүй бол боловсролын чанарын ахиц төдийлөн гарахгүй. Н.Оюунцэцэг (2023) 21 дүгээр зууны монгол суралцагчийн суурь компетнцийн “тооно” загварт математик, байгалийн шинжлэх ухаан, технологийн цогц чадамжид асуудалд шинжлэх ухаанчаар хандах, технологийг хэрэглэх, бүтээх, МХТ-ийг хэрэглэх гэх мэтийг тусгажээ. Гэвч өнөөгийн анги танхимын хаалганы цаана бага боловсролын математикийн хичээл дээр эдгээрийг хэр зэрэг дэмжиж, хөгжүүлж байгаа нь манай судалгаанд хамрагдсан суралцагчдын үнэлэмжээс харахад жигд бус байна.

Арга зүй

Судалгаанд 2023 оны 7 ба 8 дугаар сард НҮБ-ын Монгол дахь Хүүхдийн сангийн дэмжлэгтэй зохион байгуулагдсан Ковидын дараах сурлагын хоцрогдлыг бууруулахад хувь нэмэр оруулах зорилготой зуны сургалтын төсөлд хамрагдсан Дундговь аймгийн Сайнцагаан, Хулд, Эрдэнэдалай, Төв аймгийн Мөнгөнморьт сумдын ЕБС-ийн 2-5 дугаар ангийн 178 суралцагч хамрагдлаа. Дундговь аймгийн 3 суманд 3-р ангийн 61, 4-р ангийн 97 суралцагч, Төв аймгийн Мөнгөнморьт суманд 3-р ангийн 7 суралцагч, 4-р ангийн 7 суралцагч, 5-р ангийн 6 суралцагч хамрагдлаа.

Энэхүү судалгааг зохион байгуулахдаа чанарын үнэлгээний аргуудыг ашиглахыг зорьж, судалгаанд хамрагдаж буй суралцагчдаар математикийн хичээлээ дүрслэн зурах даалгавар гүйцэтгүүлсэн. Мөн судалгаанд хамрагдсан суралцагчдын хичээлдээ оролцох сэтгэл ханамжийг зургаар илэрхийлэх аргаар тандсан. Суралцагчдаар даалгаврыг гүйцэтгүүлэхдээ “Миний тооны хичээл” сэдвээр өөрийнхөө тооны хичээлээ хэрхэн төсөөлж байгаагаа зурах, сэтгэл ханамжийн тандалтыг хийхдээ хичээлд ирэхдээ, хичээл дээр, хичээл тарахад, хичээлээс сурсан зүйлдээ гэсэн дөрвөн нүдэнд амыг нь зураагүй хүний нүүрний дүрслэл дээр инээмсэглэлийг илтгэх хотгор нум, сэтгэл дундуур байгааг илтгэх гүдгэр нум, дунд зэрэг гэсэн санааг илтгэх тэгш зураасаар зурах даалгавар өгсөн. Эдгээр даалгаврыг гүйцэтгэх хугацаа нийт 40 минут байсан.

Судалгааны үр дүн


Судалгаанд хамрагдсан 178 суралцагчийн дээрх хоёр даалгаврыг гүйцэтгэсэн байдлыг авч үзвэл дараах үр дүн гарчээ.

Эхний даалгавар бол “Миний тооны хичээл” нэртэй зураг зурах юм. Энэ даалгаврын гүйцэтгэлтэй танилцахад дараах зүйлс ажиглагдаж байна.

Анги танхимд самбар зурж, дээр нь тоо, илэрхийлэл бичсэн зургийг 35 суралцагч буюу 20% орчим нь дүрсэлжээ. Энэ нь математикийн хичээл дээр нь голдуу самбар дээр бичсэн тоо бодох үйл ажиллагаа хийгддэг болохыг илтгэж байна.

Багш заагуур бариад, самбарт тайлбарлаж буй дүр зургийг 21 суралцагч буюу нийт хүүхдийн 12% нь дүрсэлсэн. Мөн 3 суралцагч багшийг хүүхдүүдийн өөдөөс хараад ширээн дээрээ сууж байгаагаар дүрсэлжээ. Энэ нь багш тайлбарлах, мэдлэг дамжуулах гэсэн хандлага одоо ч байсаар байгааг илтгэж байна.

Зураг 1. Суралцагчдын зурсан зургаас



Геометрийн дүрс, баганан диаграмм, пиктограмм зэргийг зурсан хүүхдүүд 17 буюу 9.5% байна. Мөн өгүүлбэртэй бодлого бодохыг дүрсэлсэн суралцагч 8 байна. Боломж тоолох бодлого бодож байгааг 3 суралцагч дүрсэлсэн байна. Энэ нь сургалтын хөтөлбөрийн агуулгын бүрэлдэхүүн хэсгүүд сургалтад хэрэгжиж байгааг илэрхийлж байна.

Зүрх, инээмсэглэл, нар, цэцэг зэргийг дүрсэлсэн 14 суралцагч байна. Энэ нь зурах чадвар хангалтгүй улмаас эерэг сайхныг илэрхийлэх ородлого болов уу гэж үзэж байна. Мөн нийгмийн сүлжээ, интернетийн улмаас эерэг зүйлийг дээрх зүрхээр илэрхийлэх хандлага хүүхдүүдэд нөлөөлсөн байхыг үгүйсгэхгүй.

Хүний тархи зурсан, эргэцүүлэн бодож байгааг дүрсэлсэн 3 суралцагч байна. Энэ нь тооны хичээл хүний оюун ухааныг хөгжүүлдэг гэсэн ойлголттой байгааг илтгэнэ.

Багаар ажиллаж байгаа болон гэр бүлээрээ ойд тоо бодож байгааг дүрсэлсэн зураг тус бүр нэг байна. Энэ нь математикийн хичээл зөвхөн анги танхимд ширээний ард зэрэгцэн сууж өрнөдөггүйг илтгэж байна.


Огт зураагүй 4 суралцагч байна. Даалгаврыг ойлгоогүй, эсвэл тухайн хүүхдүүд зураг зурахдаа өөртөө итгэлгүй байж болох юм.

Ерөнхийдөө багш төвтэй, багш самбарт тайлбарлах болон самбарт бичсэн тоог дэвтэртэй бодох үйл ажиллагаа голлож байгааг илтгэнэ.

Хүүхдүүд аз жаргалтайгаар инээмсэглэж байгаа, бие биедээ тусалж буй, туршилт хийж буй, мэдлэгээ амьдралд хэрэглэж буй, гар утас таблет компьютер хэрэглэж буй дүр зураг огт харагдахгүй байгаа нь хичээл дээр дээр эдгээр үйл ажиллагаа тун бага хийгдэж байгааг илтгэнэ.

Хоёрдахь даалгаврын хувьд суралцагчийг хичээлдээ ирэх, оролцох, тарах үедээ хэр сэтгэл ханамжтай байдгийг тандах зорилготой бөгөөд 178 суралцагчийн хувьд дараах үр дүн харагдлаа.

График 1. Суралцагчдын хичээлдээ оролцох сэтгэл ханамж



Нийт суралцагчдын хувьд хичээлд ирэхдээ баяртай байсан байдал хичээл дээр буурч байгаа нь харагдаж байна Энэ нь хичээл дээрх үйл ажиллагаа сонирхолгүй байгааг илтгэнэ.

Хичээл тарахад таагүй байгаа нь 1. Найз нөхөдтэйгөө цагийг өнгөрөөх дуртай 2. Хичээлийн дараа сонирхлоор хичээллэх дугуйлан секц клуб бага байгаа 3. Гэр бүлийн хувьд цагийг зугаатай өнгөрөөх боломж нөхцөл бага зэрэг олон шалтгаан байж болохыг илтгэнэ. Хамгийн гол нь хүүхдүүд сургууль дээр илүү удаан баймаар

байна. Хүүхдүүдийн дийлэнх нь хичээл дээрээ сурсан зүйлдээ сэтгэл хангалуун гэж хариулсан нь эерэг үзүүлэлт юм.

Дүгнэлт

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн зурсан зураг дотор самбарт тайлбарлах багш, самбарт бичсэн олон илэрхийлэл, шил шилээ харж эгнэж суусан ангийн зохион байгуулалт, багшийн ширээнийн ард суугаа багш зэрэг дүр зураг олон давталттай байна. Энэ нь бага боловсролын математикийн хувьд анги танхим дахь үйл ажиллагааны багш төвтэй, идэвхгүй хэлбэр оршсоор байгааг харуулж байна.

Хүүхдүүд аз жаргалтайгаар инээмсэглэж байгаа, бие биедээ тусалж буй, туршилт хийж буй, МХТ хэрэглэж буй дүр зураг (0%) огт харагдахгүй байгаа нь хичээл дээр эдгээр үйл ажиллагаа бага хийгдэж байгааг илтгэнэ.

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн хувьд хичээлдээ ирэхэд байсан сэтгэл ханамжтай байдал хичээл дээр буурч байгаа нь бага боловсролын математикийн хичээлийг илүү сонирхолтой болгох хэрэгцээ байгааг илтгэж байна.

Хэлэлцүүлэг

Багшийн арга зүйг илүү бүтээлч, суралцагч төвтэй болгоход анхаарснаар сургалтын чанарт эергээр нөлөөлнө. Санамсаргүй байдлаар сонгосон сургуулийн бага боловсролын багш нарын хувьд багш төвт сургалтыг эдүгээ ч зохион байгуулсаар байгаа нь 2014 онд батлагдсан цөм хөтөлбөрийн онолын үзэл баримтлал нь мэдлэг бүтээлгэх конструктивист онол байх гэсэн санааг анги танхимд бүрэн нэвтрүүлээгүй байгааг илтгэх аж. Иймээс сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал, голлох шинэчлэлийн үзэл санааг сайтар түгээн дэлгэрүүлэх, багш бэлтгэх, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтад үүнийг анхаарч ажиллах хэрэгцээ шаардлага байсаар байна.

Талархал

Судалгааны өгөгдлийг цуглуулахад цаг зарцуулж тусалсан нэр бүхий багш нарт талархлаа. Мөн төслийг хэрэгжүүлэх боломж олгосон Монгол дахь НҮБ-ын Хүүхдийн сангийн хамт олонд талархлаа илэрхийлье.

Ном зүй

Lalley, J. P. & Miller, R.H. . (2007). “The learning pyramid: Does it point teachers in the right direction?”. *Education* 128(1), 64-79.

Schleicher, A. (2018). *TALIS 2018: Insights and Interpretations*. OECD.

БСҮХ. (2019). *Монгол улсын боловсролын суурь мэдээллийн тайлан*. Улаанбаатар.

БШУЯ. (2023, 12 14). Retrieved from <https://www.meds.gov.mn>: <https://www.meds.gov.mn/post/134756>

БШУЯ. (2023). *Боловсрол, шинжлэх ухааны салбарын статистикийн мэдээлэл, 2022-2023*. Улаанбаатар.

Н.Оюунцэцэг. (2023). *21 дүгээр зууны боловсрол насан туршийн суралцахуй*. Улаанбаатар.

ЮНЕСКО. (2019). *Монгол улсын боловсролын бодлогын тойм шинжилгээ*. Улаанбаатар.

TEACHER-CENTERED LESSON BEHIND THE DOOR

^aAmartuvshin.D

^aTeachers School, MNUE

Corresponding author: Amartuvshind@msue.edu.mn 

Abstract

This study assessed the quality of mathematics education and the satisfaction levels of 178 elementary school students from secondary schools by qualitative methods to draw math lessons and satisfaction. When drawing their math lesson, the majority of the students who participated in the study depicted the teacher explaining the math lesson on the blackboard. This indicates that until now the lesson in the classroom is teacher-centered. Also, the image of sitting at a table arranged in a row and thinking about problems written on the board in a notebook is repeated many times, which indicates that the students' activities in the mathematics lesson are not active. The absence of scenes of children happily smiling, helping each other, experimenting, playing, applying their knowledge to life, or using mobile phones, tablets, or computers indicates that such scenes are not common in the classroom. On the satisfaction drawing task, it can be seen that the students who participated in the study were happy to come to class. This indicates that the activity in the lesson is not interesting. On the satisfaction drawing task, it can be seen that the participant students' satisfaction decreased in the class. This indicates that the activity in the lesson is not interesting.

Keywords

Explain to the blackboard, Passive learning, satisfaction, mathematics lesson